

ний хэрэгслийг ашиглах явдал улам ч чухал болж байна. Ийм нөхцөлд хамтын ажиллагааны нэг хэлбэр болсон хувь нийлүүлсэн нийгэмлэг хоёр талд ашигтай болохоо 40 жилийн турш харуулав. Цаашид энэ хэвээр ажиллах нь зүйтэй гэж би хувьдаа боддог. Манай тал төмөр замыг дангаар хүлээн авахад боловсон хүчин материал техникийн баазын хувьд бололцоотой байх. Харин олон жил ашигтай болохоо харуулсан энэ нийгэмлэг зөвхөн манай улсад төдийгүй бусад оронд ч үлгэр дууриал болох ач холбогдолтой гэж үздэг

Дамжин өнгөрөх ачааны хувьд гэвэл Зөвлөлт, Хятад хоёр улс хэвийн ажиллагаагаа бүрэн сэргээж байгаа энэ үед ачаа тээвэр улам нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ хоёр орны харилцаа муудсан 60—70 оны үед төмөр замаар дамжин өнгөрөх ачаа бараг үгүй болж Монголын төмөр зам ихээхэн хохирол үзэж Улаанбаатараас урагш Хятад улстай хил залгасан Замын-Үүд хүртэл зарим өртөө, зөрлөгийг хааж ажиллагсдын орон тоогоо их хэмжээгээр хассан билээ. Харин Зөвлөлт, Хятад хоёр орны харилцаа сайжирч эхэлсэн үеэс дамжих ачаа тээвэр дахиад эрс нэмэгдсэн. Одоо хоёр улсын харилцаа бүрэн хэвийн болсон нөхцөлд улам нэмэгдэнэ байх гэж бодож байна. Хоёр том гүрний харилцаа сайжрахад түүний хил залгаа Ази, Номхон далайн орон, тэр ч байтугай Европ, Азийн орнуудын техник эдийн засгийн харилцаа өргөжиж ачаа ба зорчигч тээвэрлэлт улам их нэмэгдэнэ гэж үзэж байна. Энэ ерөөл бат орших болтугай.

ДОРНОДАХИНЫ КАПИТАЛИСТ ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Н. Дангаасүрэн

Дорнодахин буюу өмнөдийн нэлээд улс орон капиталист замаар хөгжиж байна. Эдгээр орны хөгжлийн үйл явц харилцан адилгүй түүхэн уламжлал, нөхцөл байдлын ялгавартай гүнээ уялдаж байна. Тиймээс орон тус бүр капиталист хөгжлийн өвөрмөц дүр загвараар хөгжих болсон нь гайхалтай биш билээ. Үндэсний бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, олон улсын хэмжээнд зүй ёсны байр сууриа эзлэх зарчмыг эдгээр орны төр, намуудын бодлогод тусгажээ. Ардчилал, хүний эрхийн асуудал нийгмийн хөгжлийн шийдвэрлэх баталгаа болон нэгэнт дэвшигдэн гарч иржээ. Хөдөлмөрчин олон улс төрийн шаардлага тавих, жагсаал хийх, ажил хаях, хэвлэн нийтлэх, гадаадын хэвлэл мэдээллийг хүлээн авах, улс төрийн эвлэл холбоо, эдийн засгийн элдэв нэгдэл, хоршоолол байгуулах зэрэг эрхийг ихэвчлэн олсон байна. Төрийн үйл хэрэгт хөдөлмөрчид идэвхтэй оролцон, эрх ашгаа хамгаалах, үндэсний бүрэн эрхт байдлыг хангахад чиглэсэн ардчиллын эдгээр үйл ажиллагаа нь эртний дорнодахины журам, дэглэм, мөн өрнөдийн хараанд оршиж байсан өнгөрсөн үестэй зүйрлэшгүй ахицтай байна. Өнөөгийн дорнодахины орон бүр биеэ даасан байдал, үндэсний соёл иргэншлээ нандигнан хадгалах явдлыг орчин үеийн шинжлэх ухаан-техник зохион бүтээх чадавхиар

бусад хөгжингүй гүрэнтэй наанадаж мөр зэрэгцэх эрмэлзлэлтэй нягт холбож байна. Харин хичнээн хоцрогдсон ч гэсэн өөрийгөө аль нэгэн орны эрхшээлд сайн дураар оруулах, соёл иргэншлээ арчин устгахыг эрмэлзэж байгаа ийм инээдэмтэй нэг ч улс үндэстэн урьд ч байсангүй, цаашид ч гарахгүй бололтой. Капиталист хөгжлийн замд орсон улс түмэн ч шинжлэх ухаан, техникийн бие даасан хөгжлөөр нийгмийн дэвшилт хийхийн төлөө тэмцэж, энэ замаар яваад үндэс ний сэргэн мандалтын эрмэлзлэлээ хангаж чадах эсэхээ сорьж байна. Энэ сорилтоор хөгжлийн нэг хэсэг асуудлыг лавтай шийдэх байх. Гэхдээ нийгмийн шинж чанартай олон асуудал тунаж үлдсэн цагт тэдгээр орны ард түмэн зохих шийдвэрээ гаргах ээлж ирнэ. Энэ бол эдгээр ард түмний өөрсдийн хэрэг юм. Дорнодахины буюу өмнөдийн ард түмэн өнөө ч хөгжлийн олон асуудлаар нааштай үр дүнд хүрээд байна. Энэ өгүүлэлд дорно дахиныг үндсэндээ газарзүйн үүднээс дорно буюу өмнөд гэдэг хам ойлголтоор нэрлэж байна.

Дорнодахин буюу өмнөдийн улс түмэн шийдвэрлэгдээгүй олон асуудалтай өнөө ч тулгарч байна. Үүний дотор хөгжлийн асуудал анхаарлын төвд зүй ёсоор дэвшигдсэн юм. Саяхан болтол дорнодахины улс түмний эртний соёлын цаглашгүй уламжлалыг ч хайхарч үзэхгүй ердөө «хоцрогдсон» дорно буюу «ядуу» өмнөд гэж нэрлэх явдал байсан. Чухамдаа эдгээр ард түмэн сүүлийн хэдхэн зуун жилд техник, шинжлэх ухааны тодорхой салбарт «умард буюу «өрнөд»-ийн хойно орсон байв. Түүний өмнөх бүх үед дэлхийн соёл иргэншлийн тэргүүний байранд дорнодахин ихэвчлэн оршиж байжээ. Өнөөгийн байдлаар үзэхүү дорнодахины улс түмэн тэрхүү тодорхой салбарт гарсан түр зуурын хоцрогдлыг нөхөөд урагшлан гарах итгэл төрүүлэхүйц явцаар хөгжиж байна. Энэ талаар орон бүр жигд биш ч гэсэн хөгжлийн хандлага иймэрхүү байна. (Дорнодахины социалист улс түмний талаар тусгайлан бичих тулд энэ удаа, дорно дахины капиталист хөгжлийг энд авч үзэж байна. Н. Д.) Дорно дахины соёл иргэншил хэзээ ямагт өнгө жавхаатай байж бусад тив орны айлчин гийчний хүндэтгэлийг хүлээсээр ирсэн нь нийтэд илэрхий юм.

Дорнодахин буюу өмнөдийн улс түмнээс хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан гайхамшигт хувь нэмэр нь гандан бууршгүй билээ. Хүн төрөлхтний цаглашгүй баялаг нь тэрхүү олон үндэстний ялгаа, тэдгээр соёл иргэншлийн ялгаа гэдгийг өнөө дэлхий даяар хүлээн зөвшөөрч байна. Америк тивд индианчууд, австрали тивд аборигенчууд, Шинэ Зеландад маори нар, Хоккайдо, Хонсю арал дээр айну нар бусад оршин суугчдаас шоовдор байвал тэдгээр тив нутгийн ардчилал гэдэг яриа хоосон цууриа болох биз ээ. Өмнөд африкт африкчуудыг дээрэлхэн хавчигчдыг жинхэнэ «варвар» гэхээс биш, алив эрт, дунддын улс түмнийг «варвар» гэж нэрлэгчид үнэн бодит байдалд бусад ард түмнийг, тэдний соёл иргэншлийг үнэлэх чадваргүй ухар бодлын харгаа юм. Өнөө тэр «варвар» гэдэг нэрийг тэрхүү нэр томъёог зохиогчдод буцааж өгөхөөс өөр аргагүй болжээ. Тэд тэр нэрээ дуртай бол өөрсдөө зүүнэ биз. Дэлхий дахинд олон үндэстэн, угсаатан, янз бүрийн арьстан тэгш адил эрхтэй оршин тус тусын соёл иргэншлээ хөгжүүлэн, оюун сэтгэлгээний давтагдашгүй байдлаа хадгалан, бус улс, үндэстэн найрсаг харилцаатай, харилцан ойлголцож байх эрүүл саруул санаа бодол эцсийн эцэст хүн төрөлхтний дэмжлэгийг хүлээнэ гэдэг итгэл өнөө үед нийтлэг шинжийг олж байна. Нэг улс гүрэн нөгөөд хүсэл зоригоо тулгахгүй байх, улс түмэн

бүр их бага адил өөрсдийн хүсэл бодлоор аж төрөх эрхийг гаднаас хавчин шахахгүй байхад олон улсын харилцааны хэв хэмжээ орших билээ.

Урьд цагт алив улс үндэстний тусгаар тогтнолыг хангахад зэвсэгт хүчин баталгаа болж байжээ. Өнөө гагцхүү зэвсэгт хүч, хилийн харуул тусгаар тогтнолыг авран хамгаалж байх үүргийг дангаар дийлэхгүй болсон байна. Шинжлэх ухаан-техникийн эриний шинэ нөхцөлд тусгаар тогтнол-бие даасан байдлаа хадгалах гэдэг бол хөгжингүй гүрнүүдийн мэдээллийн түрэмгийлэл, үзэл суртлын түрэмгийлэл, соёлын түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал юм. Энэ бол үндэстний бие даасан сэтгэлгээг харийн үзэл суртлын ноёрхлын эсрэг сэргүүлэн тавих, харийн далд санаа бүхий мэдээллийн эсрэг өөрийн мэдээллийг сэргүүлэн тавих, харийн соёлын түрэмгийллийн эсрэг үндэстний соёлоо сэргүүлэн тавих явдал билээ. Гэвч шинжлэх ухаан техникийн ололтоор тэдгээр хөгжингүй гүрний хэмжээнд хүрэхгүйгээр эдгээр тэгшгүй байдлыг эцэс болгож чадахгүй гэдгийг түүхийн гашуун сургамж, бодит байдал юунаас ч илүү ил тод хэлж өгч байна. Байгалийн аль ховор баялагаа шавхагдтал гадагш зөөлгөөд, өндөр хөгжилтэй орны орчин үеийн шинжлэх ухаан-техникийн эрхшээлд хясуулж боолгон байгаа бодит нөхцөлд тэгш эрх, харилцан хүндэтгэл гэдэг бол хоосон дуулиа юм. Дорно буюу өмнөдийн олонхи орны ард түмэн байгалийн болон оюун санааны нөөцөө өөрсдийн хэрэгцээнд ашиглаж чадахгүй гадагш гаргаж байдгийн уршгаар үндэстний буюу улс орны ядуурал доромжлолыг амсаж байна. Тэдний хойч үеийнхэн, хойчийн хойч бүх үеийнхнийг үндэстний энэхүү гунирхлаас аврах цорын ганц зам байна. Энэ бол ард түмэн бүр, үндэстэн бүр өөртөө итгэх, хүчиндээ итгэх явдал болно. Тэд эрүүл саруул ухаан бодолдоо итгэх учиртай. Ийнхүү зориглон шинжлэх ухаан-техникийн талаар бусад улс түмний танин мэдээгүйг танин мэдэх замналаар хөгжвөл ирээдүйдээ найдаж болно. Үндэстэн бүрийн давтагдашгүй чанар, тэдгээрийн соёл иргэншлийн давтагдашгүй шинж чанар урьд ч байсан, тэр давтагдашгүй шинж чанар нь шинжлэх ухаан-техникийн эринд ч шинээр залган хөгжих болно. Улс гүрний нэг нь нөгөөг ноёрхох, нэг үндэстэн нөгөөд соёл иргэншлээ тулган хүлээлгэхийг оролдох, нэг улс үндэстэн нөгөөд амьдралын хэв маяг, үзэл бодол, сэтгэлгээний онцлогоо хүлээлгэхийг оролдох бол манай эриний хамгийн зэрлэг балмад үзэгдэл юм.

Хүн төрөлхтөн хөгжихдөө олон үндэстний соёл иргэншил тус бүрийн бүрэн бүтэн байдал, тэгш адилаар хөгжих, жинхэнэ тэгш эрх, тэгш нөхцөлийг олон улс түмний хөгжлийн хөдлөшгүй баталгаа гэж үзсээр иржээ. Ийм байдал үндэстний соёлоо хөгжүүлэхийг үндсэрхэг үзэл, «үндэстний явцуурал» мэтээр дайрах нь мөн чанартаа их гүрний ноёрхлын өмнө бага хөгжилтэй улс түмнийг сөгдүүлэх гэсэн оролдлого юм.

Өнөөгийн дэлхийн хөгжлийн тодорхой нөхцөлд хөгжингүй их гүрний үндэстний дээрэнгүй үзэлтэн, даврах үзэлтнүүд, үндэстний ялгаа гаргах хэрэггүй гэсэн найрсаг хэлбэрээр халхлан бага хөгжилтэй улс түмнийг уусгах, өөрсдийн хэл, зан заншилд живүүлэх бодлогыг идэвхтэй үргэлжлүүлж байна. Хуучны дарангуйлагчид, дайнч төрүүд нүдэнд харагдахгүй, чихэнд сонсогдохгүй болж, ардчилсан дүртэй, энх тайвны тунхаглал урдаа барьсан улс гүрэн олширсон ч гэсэн нөгөө

мөлжих, ноёрхох, уусгах бодлого нь хэвээрээ байна. Үүнийг шинэ үеийн бага хөгжилтэй улс үндэстний өмнө тулгарч буй хөгжлийн гол бэрхшээл, тэр байтугай бага хөгжилтэй улс үндэстний оршин тогтнох эсэх, соёл иргэншлээ үүрд хадгалах эсэхийн хамгийн ноцтой саад гэж зүй ёсоор сэрэмжлэн үзэх нь хойшлуулашгүй шаардлага болж байсан, цаашид удаан хугацаанд энэ байдал хадгалагдах бололтой. Нэлээд дэвшилт байгуулалтай гэсэн улс оронд ч бусад айл хөрш улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, хүчээр түрий барих, оюун сэтгэлгээний эрхшээл хүрээндээ хашин барих ил далдын ажиллагаа зогсоогүй байгаа үнэнийг нуух хэрэггүй.

Дорнодахин, өмнөдийн улс түмэн өнөө үед үндэсний бие даасан байдлыг хангахад хүрэлцэхүйц чадалтай, олон улсын зах зээлд зохих байр эзлэхүйц салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зүй ёсоор анхаарал тавьж байна. Гадаадын техник, технологи, оюун санааны нөөцийг царайчлахгүй, харин өөрийн оюун санааны бүтээлч хүчинд тулгуурлан технологи, техник зохион үйлдвэрлэлд нэвтрүүлэх чадварыг нэг буюу хэд хэдэн чиглэлээр эзэмшвэл уул орон хөгжингүй түвшинд харьцангуй бага зардал, хүчээр, харьцангуй ахар хугацаанд хүрч болохыг мөрөөдөлд хөтлөгдсөн хоосон санааны үүднээс биш, дорнодахин, Өмнөдийн улс түмний өөрсдийн туршлагаар батлан дэвшүүлж одоо нэгэнт болох боллоо. Хөгжингүй улс гүрэн оюун санааны бүтээгдэхүүн (техник, бусад бэлэн эдлэл, хэрэгсэл) гаргаж байхад хөгжиж байгаа орныхон байгалийн баялагаа гаргаж байгаа тэнцвэргүй гадаад харилцааг халж өөрчлөхгүйгээр тэгш эрх, харилцан ашгийн тухай ярих нь гэнэн юм. Тэр тусмаа байгалийн нөөцийг хөндөх нь улс орны ойрын хөгжил төдийгүй хойч үеийнхний хувь заяатай холбоотой эмзэг асуудал юм. Байгаль орчныг хамгаалах үйлсийг орчин үеийн хөгжлийн хэтийн төлөвтэй ямагт хамт дэвшүүлж шинжлэх ухааны олон талын мэргэжилтний судалгааг үндэс болгох зарчмын асуудал энд чухал байр эзлэх учиртай байна. Энд эрүүл агаар, цэнгэг усны асуудал ноцтой болж байна. Дорнод, өмнөдийн нэн ховор ургамал, амьтад сүйрч байгааг зогсоон, бүрэн хамгаалалд авах асуудал нь заримдаа уул орны хүрээндээс хальж олон улсын анхаарал халамжийг хүлээх шаардлага зүй ёсоор гарч байна.

ЮНЕСКО-гийн ерөнхий захирал нэрт биологч профессор Федерико Майор Сарагос манай гаригийн байгаль орчныг хамтын нэгэн санаа сэтгэлээр хамгаалахыг уриалсанд зөвхөн талархал илэрхийлэх хангалтгүй ээ. Харин улс, бүс нутаг, тив бүр хамтын хүч чармайлт тавих шаардлагатай болоод байна.¹

«Бид цаашаа хүлээж болохгүй, маргааш гэхэд оройтно!» гэсэн уриаг байгаль орчныг хамгаалахад ч, орчин үеийн өндөр хөгжилд хүрэх асуудал дээр ч хамт ойлгож, хамт шийдвэрлэх хэрэгтэй болжээ.

Дэлхийн хөрсийг техникээр эргүүлэн сэглэж агаар мандлыг тоосжуулж, хөрсний үржил шимийг алдагдуулж байна. Иймээс нүүрс, нефть бусад утаат түлшийг хэрэглэхээс татгалзан өөр түлшээр орлуулах аргыг яаралтай боловсруулж амьдралд нэвтрүүлэх нь хүн төрөлхтний оршин тогтнох эсэхийн асуудал болон тавигдав. Түүний дээр ундааны усны гачигдал гүнзгийрсээр байна. Байгалийн эрдэс баялагийн нөөц мэдэгдэм багасч байна. Энэ бүхнийг сансрын нөөцөөр орлуулна гэдэг онолын хувьд хялбар мэт боловч оюун ухааны асар өндөрт хүрсэн мэдлэг хөрөнгө хүч шаардаж байна.

Чухамхүү ийм учиртайг дорнодахины эртнээс өнөр соёлтой ард түмний өнөө үеийнхэн бүгдээр бодож сэтгэмээр байна. Орчин үеийн өрнөдийн шинжлэх ухаан-техникийн ололтыг дорно дахины улс түмэн хуулан дууриахад учир нь байгаа биш юм. Харин өөрсдийн соёл иргэншлийн өнөр суурин дээр өөрийн хөгжлийн үр шим болсон шинжлэх ухаан-техникийг шинээр ургуулахад жинхэнэ ирээдүй, амьдрах чадвар, өрсөлдөх чадвар оршиж байх бололтой. Хөгжил бол гаднын эрээвэр цуглуулга хэзээ ч байдаггүй, харин өөрийн төрсөн үр ач шиг ургаж цэцэглэдэгт түүний мөн чанар оршиж байна. Дорно, өмнөдийн улс түмний хөгжлийн түвшинг нийгмийн байгууллын шинжээр биш, орчин үеийн шинжлэх ухаан-техник зохион бүтээж байгаа чадавхи, үндэсний соёл иргэншлийн шинэ цэцэглэлт дэгжин сэргэж байгаа үйл явцын байдлаар сая үнэн зөв тодорхойлж болно.

Хөгжиж байгаа орны бэлэн бүтээгдэхүүн хөгжингүй орны хэрэгцээнд гологдох явдал нийтлэг шинжтэй байна. Учир нь хөгжиж байгаа олонхи орон шинжлэх ухаан-техникийн дэлхийн түвшингээс харьцангуй доогуур үйлдвэр, техник, технологи гадаадаас бэлэн авч байна. Ийнхүү гадаадаас авсан үйлдвэр, багаж, төхөөрөмж нь бусад орны түвшингээс ямар нэг талаар заавал хоцрогдсон байх учраас гарсан бүтээгдэхүүн нь олон улсын зах зээл дээр борлогдохгүй буюу хямд үнэлэгдэж байна. Нөгөө талаар гадаадаас авч буй сэлбэг хэрэгслийн үнэ хэмжээгүй ихсэж байна. Хүн ам олонтой улс орны байдал бүр хүнд байна. Тэдгээр орны үндэсний орлого нь үргэлж өсөж байгаа хүн амын хэрэгцээнээс илүү гарахгүй байна. Үүнээс болоод шинжлэх ухаан-техникийн шийдвэрлэх салбарт оруулах хөрөнгө дутагдаж байна. Өөр бэрхшээл гэвэл, хөгжингүй улс гүрнүүд бага хөгжилтэй улс гүрэнд хөл дээрээ түргэн зогсох боломж олгох ач холбогдол бүхий төмөрлөг хайлах боловсруулах, суурь багаж зэрэг чухал салбарын үйлдвэрийн багаж төхөөрөмжөөр хангах, үндэсний биеэ даасан сэтгэлгээ, шинжилгээ судалгаа хийхэд саад тавьж байгааг онцлон дурьдууштай байна. Хэдий энэ мэт бэрхшээл саад үлэмж боловч дорнодахин, өмнөдийн ард түмэн шинэ эриний өмнөх арван жилийг шинэ ахицын үе болгох эрмэлзлэлтэй байна.

Аль нэгэн давуу хүчтэй буюу хөгжилтэй гэсэн орны аясыг дагаж түүний эрхшээл дор дарлагдаж мөлжигдөж дадсан боолын үзлээс ангижрах явдлыг зөвхөн төрийн тусгаар тогтнолыг тунхагласан төдийгөөр шийддэггүй юм байна. Улс хоорондын тэгш эрх, тусгаар тогтносон орны чөлөөт байдал, хүмүүсийн сэтгэл санааны чөлөөт байдал, тэр тусмаа үзэл суртлыг өөрсдөө шийдвэрлэх эрхээ эдэлж чадахгүй өөрийн хүчиндээ үл итгэх, дарлагдсан үндэстний өөрийгөө доогуурт тавих үзлийн уршигтай зууралдан нийлсэн чөлөөт биш, хязгаарлагдмал, аймхай, сүрдэмхийн илрэл газар сайгүй ажиглагдаж байна. Энэ арчаагүй байдлыг гэтлэн давахгүйгээр нийгмийн хөгжингүй түвшин тэр тусмаа шинжлэх ухааны сэтгэлгээний чөлөөт нөхцөлийг хангаж чадахгүйг бага хөгжилтэй улс түмний амьдрал улам тод харуулж байна. Тухайлбал алив номлолоос чөлөөтэй байх амьдрал, бодит байдалд хүний ёсны эрүүл саруул ухаанаар ханддаг хэдийнээ мартсан байр сууриа эргэн санахыг түүх шаардаж байна. Хүний хэвийн ухаан санаа ийм байвал зохино.

Израиль улс гурван сая гаруйхан хүн амтай 14 мянган хавтгай дөрвөлжин км дэвсгэр нутагтай боловч орчин үеийн аж үйлдвэрийн

шийдвэрлэх салбар бүхий цогцолбортой билээ. Израилийн Димон дахь цөмийн төв, негевийн цөл дахь газар дорхи цөмийн төвийг өнөө дэлхий даяар мэдэх болжээ. Тэрчлэн ураны эрдсээр дутмаг учир фосфоритыг технологийн өвөрмөц аргаар боловсруулан орлуулж байгааг дурьдаж болох юм. Хэрэв Израиль улс энэ бүхнийг улсынхаа бүтээн байгуулалтад зориулсан бол тус орны жинхэнэ эрх ашиг, ойрхи дорнодын улс түмэнд таатай байхсан билээ. Араб-Израилийн мөргөлдөөнийг зогсоох, тэдний хооронд харилцан ойлголцуулах нь энэ хоёр талын алин алины эрх ашигт нийцнэ. Ингэж нийцэх зохистой болзлыг олж тогтоох боломж олгох нь ертөнцийн энэ хэсгийн улс түмний сонирхлын тулгамдсан асуудал юм. Энд хэвшмэл үзэл санааны уршиг хичнээн ноцтой хэвээр байгааг амьдрал харуулж байна.

Хөгжиж байгаа улс орны хоорондын алив мөргөлдөөнийг улс төрийн аргаар зохицуулах, зэвсэглэлд гаргах зардлыг багасгах уур амьсгалыг идэвхтэй дэмжих явдал онц асуудал болон тулгарчээ. Бусдын нутагт цэргээ оруулах ямар нэгэн шалтгийг дэлхий нийтээр үгүйсгэх хууль зүйн үндэслэлийг тогтоож хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бусад орны нутагт ямар нэг хэлбэрээр зэвсэгт хүчин оруулах, байрлуулах, бусад орны эсрэг аль нэг шалтаг заан хүч хэрэглэхийг хориглох талаар олон улсын эрхийн хэм хэмжээг чандлан тогтоох шаардлагатай байна.

Америкийн нэрт эдийн засагч профессор Джон Кеннет Гэлбрейт, нийгмийн аль байгуулал нь илүүг энх тайван бүтээн байгуулалтын үйл явцаар түүх шийдэх учиртай, зэвсэгт мөргөлдөөн энэ асуудлыг шийдэх хэрэглүүр байж таарахгүй гэсэнтэй санал бүрэн нийлж байна.² Аль аль талын нааштай туршлагаас харилцан сурах юм их байна. Социалист нийгмийн байгуулалтай улс оронд ч гэсэн шийдвэрлэгдээгүй асуудал, доголдол, дутагдал хүрэлцээтэй байна. Ялангуяа хуучин сэтгэлгээ манай урагшлах замд аюултай бэрхшээл учруулсаар байна. Өөр өөрийн нийгмийн байгууллын зөвхөн амжилтыг хараад, дутагдлыг олж, хардаггүй байснаас аль ч нийгмийн байгуулал багагүй хохирол үзлээ. Хөгжиж байгаа ертөнц дахь цэргийн элдэв эвсэл, сөргөлдөөнд гаднын нөлөө, дарамт тодорхой шалтгаан болж байна. Ард түмний нуруун дээр үүрэгдэж байгаа эдгээр ачааллыг шийдвэртэй авч хаях цаг болжээ. Ингэснээр аль ч орон зөвхөн хожих болно. Хөгжиж байгаа орны өр төлбөрийн үлэмж хэсэг үүнтэй шууд буюу шууд биш холбоотой байна.

Байгалийн баялагаа худалдахад түшиглээд байх бол тун осолтой, хамгийн аюултай зам юм. Маргаашаа боддоггүй ганц нэг хүн өөртөө төдийгүй нийгэмд осолтой байтал бүхэл улс үндэстэн маргаашаа бодохгүй бол яах вэ гэдэгт тухайн улс үндэстнээр үл барам хүн төрөлхтний амьдралын түвшинд нөлөөтэй билээ. Зүүн өмнөд азиас зургаан мянга шахам хавтгай дөрвөлжин км нутагтай, 230 мянган хүн амтай Брунейг авч үзэж болох юм. Тус орон нефть гаргалтаар дэлхийн 23 дахь, хий гаргалтаар дөрөв дэх байранд орж Англи, Японы төхөөрөмжтэй орчин үеийн боловсруулах үйлдвэр, дамжуулах хэрэгсэл эзэмшиж байна. Хүн амын амьдралын түвшингээр маш өндөр байна. Энэхүү лалын шашинт орон нь арабын дорнодын нефть гаргагч улс орны адил байгалийн буянаар туйлж байна.

Үндсэн хүн ам нь алив албан татвараас чөлөөтэй, эмнэлэг, эмийн үнэ төлбөргүй үйлчилгээ, боловсролын үнэгүй үйлчилгээгээр хангагджээ. Тэр байтугай лалын шашны их дагшин-ариун Меккед очиж мөргөл үйлдэхэд ч улсаас тусална. Гадаадад суралцах оюутан тус бүрийн зардалд үлэмж хөрөнгө гаргаж байна.

Арабын нефтийн их баялагтай хэсэг орон өнөө ч хорин нэгдүгээр зуунд байгаа сэтгэлгээг төрүүлж байна. Бүсийн явцуу хүрээнд хашигдалгүй дэлхийн зах зээлийн ханшаар чухамдаа үнэ хаялцуулсан худалдаагаар эрдэс, нефтиэ борлуулж олз омог илүүтэй болсон давуу тал тэдэнд бий. Энэ наяд оны зарим үед зөвхөн Арабын нэгдсэн Эмиратын хүн ам тутамд жилд оногдох дундаж орлого 23 мянган доллар шахам байлаа. Гэтэл АНУ-д хүн амд оногдох дундаж орлого 11,8 мянган доллар байх жишээтэй байна. Австралид хүн амд оногдох дундаж орлого 5700 доллар дөнгөж хүрч байна. Олон улсын түвшинд байгуулсан агаар, усан буудал, шилдэг засмал зам, хамгийн өндөр соёл иргэншилд зочилсонтой адил сэтгэлгээг төрүүлэх өнгө үзэмж арабын нефтийн орнуудад байна. Гэхдээ үйлдвэр нь орчин үеийн боловч үндсэндээ, гадаадын тоног төхөөрөмжтэй юм. Шинжлэх ухааныг зохих өндөрлөгт тавихын оронд хамаг хөрөнгөөр бэлэн зэлэн зүйл худалдаж авахыг урьдал болгож байна.

Чухамхүү ингэж эрдэс баялагаар бусад хөгжингүй орны оюун санааг худалдан авч байгаа нь арабын эдгээр орон оюун санааны нөөцөөр ядуу дорой хэвээр байгааг харуулж байна.

«Мянга нэгэн шөнийн үлгэрт» өгүүлдэг баян чинээлэг амьдралыг түмэн үеийн арабчуулынх болгох чадварыг гагцхүү тэдний өөрсдийн оюун сэтгэлгээ өгнө. Эдийн засгийн хөгжлийн ойлголтыг оюун санааны хөгжлийн ноён оргилууд болсон шинжлэх ухааны шинэ нээлтүүдээс салгаж үзэх үндэсгүй билээ.

Дорно, өмнөдийн улс түмэн, түүний дотор арабын энд дурдсан улс орон орчин үеийн төмөрлөг хайлах боловсруулах техник, технологи, электротехник, радиотехник, биотехнологи, биофизик, биохими, микробиологи гэх мэтчилэн орчин үеийн чухал гэсэн чиглэлээр авьяастан ухаантнаа ажиллуулбал яасан их юм бүтээхсэн бол! Үүнд дорнодахины ард түмний төрөлх авьяас билгийн хүч арвин гэдэгт хэн ч эргэлзэхгүй байна. Гагцхүү үндэсний хөрөнгө хүчийг хуваарилах явцад доголдол их байна. Нөгөө талаар аль ч оронд түшмэдийн хүнд суртал хөгжилд ноцтой саад хийж байна. Арабын зэрэг аль ч оронд үндэсний баялгийг утга учиргүй бүрэлхэх явдал үргэлжилсээр байна. Хэрэв улс түмэн хүчээ чиглүүлэн дайчилж чадвал оюун санааны өндөр түвшинд хүрч болдгийг дорно дахины ард түмний өөрсдийн туршлага батлаад өгч байна.

Япон улсыг хөгжлийн түвшинг харгалзан «өрнөд» буюу «умардын» улс орны дотор оруулах нь байдаг боловч энд жинхэнэ дорно дахины орны нь хувьд орууллаа. Хөгжлийн үйл явцаас үзэхэд «дорнодахин» буюу «өмнөд» гэдэг нь гагцхүү «хоцрогдлын» нэр томъёо байсан цаг үе эргэлтгүй өнгөрч байна гэдгийг тэмдэглэхэд илүүдэхгүй биз.

Японы аж үйлдвэржилтийн зуун жилийн үйл явцад сургамжтай зүйл их бий. Дэлхийн II дайнаас хойш тус орны аж үйлдвэр бүхэлдээ шинэчлэгдэн өндөр түвшинд хүрсэн байна. Японы авьяас төгөлдөр ажилч хичээнгүй ард түмний хөдөлмөр юунд хүргэв: Энэ зууны наяд онд ган боловсруулалт, программт удирдлагатай суурь багаж,

үйлдвэрийн робот, интеграл зураглал, авто машин зэргээр АНУ-ыг гүйцэж түрүүлээ.³ Японы техник дэлхийн аль ч өнцөг буланд тэр байтугай АНУ, Англи, Франц, Баруун Герман зэрэг нэн өндөр хөгжилтэй улс орны дотоод зах зээлд нэвтрэн бэхэжжээ. Ялангуяа, электрон техник, бусад жижиг нарийн хийцэд багаж төхөөрөмж, бүтээгдэ хүүнээр аль ч орны худалдан авагчдын сонирхлыг татаж байна. Япончууд хөгжлийн энэ шатанд хүрэхдээ, гадаадын хамгийн шилдэг техникийг авч хэрэглэхээс, түүнийг дууриан үйлдвэрлэхээр дамжин бүр давуу үйлдвэрлэх түвшинд хүрчээ. Давуу үйлдвэрлэснээр өрсөлдөх, давамгайлах болж, үйлдвэрлэлийн цаашид ахих урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлж байна. Түүхэн ахар богино хугацаанд хамжилт олсон нь хөгжлийн стратегийг зөв боловсруулан бие даасан бодлогыг тууштай барьж, үндэсний эрх ашгийг удирдлага болгон чадсантай юуны урьд холбоотой байна. Япон улс анхнаас хөгжингүй аль нэг гүрний эрхшээлд оролгүй олон улсын зах зээлийн өрсөлдөөнийг авхаалжтай ашиглахын хамт бусдын улс төр, үзэл суртал, соёл, эдийн засаг, техникийн ноёрхолд орсонгүй. Энэ талаар аль хүчирхэг гэсэн оронтой тодорхой зайнаас харилцах үйл ажиллагааны хэм хэмжээг тохируулжээ. Үүний хамт бүр анхнаас эхлэн үндэсний хүнд аж үйлдвэрийн гол бүтэц-төмөрлөг хайлах, боловсруулах, суурь багаж үйлдвэрлэх зэрэг нэн чухал салбарыг хөгжүүлэхэд онцгой анхаарал тавьжээ. Дэлхийн шинжлэх ухаан-техникийн хувьсгалын хамгийн шилдэг ололтыг тусган авах, түүнийг цааш ахиулахад идэвхтэй хувь нэмэр оруулах явцаар орчин үеийн шинжлэх ухаан-техникийн маш олон салбарт тэргүүний байранд орсон байна.

Үйлдвэрийн бүтээгдэхүүний дээд чанартайг дотоод хэрэгцээнд зориулж гадаадад илүү гарсныг зориулдаг, түүнчлэн гадаадын хүнсний бүтээгдэхүүнээс өөрийнхийг найдвартайд үздэг зэрэг өрнөдийн хөгжингүй орны шинж нь хүртэл учир шалтгаантай ажээ. Энэ бүхэн явцуу үзэл санаанаас биш бодит байдлаас урган гарчээ.

Өнөөгийн Япон улс бол шинжлэх ухаан-техникийн урьд үзэгдээгүй ахицыг ирэх зуунд гаргах оюун санааны үлэмж чадавхтай орон болжээ. Өнөөгийн японыг зуун жилийн явцтай нь зүйрлүүлэн үзэхүүл, эрдэмтэд, төрөл бүрийн мэргэжилтэн, зохион бүтээгчид, үйлдвэрлэл, борлуулалт, хангамжийг зохион байгуулагчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл нь асар өргөжсөн байна. Үйлдвэрлэл-судалгааны нэгжүүдийн бие даасан үйл ажиллагаанд асар их боломж нээгджээ. Үйлдвэрлэлийн нэгжид үйлдвэрлэгчид, тэдний хамтлагуудын байр, эрх мэдэл дээшилж хуваарилалтанд оролцох эрх мэдэл өргөжжээ. Япон болон орчин үеийн бусад капиталист чиглэлээр хөгжиж байгаа дорно дахины оронд ч гэсэн энэ мэтээр хувь хүн, хамтлагийн эрх үүрэгт мэдэгдэхүйц өөрчлөлт оржээ. Хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг язгуур угсаа, хөрөнгө биш, харин тэдний эрдэм мэдлэг, авьяас чадвар, нягт нямбай ажиллагаа тодорхойлохуйц баталгаа болсон нь хөгжлийн чухал урьдчилсан нөхцөл юм. Үйлдвэрлэл, шинжлэх ухаан, зохион бүтээх алив хамтлаг, хоршоолол, нэгдлүүд нь гадаадтай худалдаа хийх мэргэжилтнээ солилцох, мэдээлэх зэрэг бүх боломжийг гартаа авчээ. Гадаадад туршлага судлах, мэргэжилтэн бэлтгэх, техникийн солилцоо хийх зэрэгт хувь хүн, хоршоолол,

нэгдлүүд, соёл шинжлэх ухааны бүх салбарт хаалт байхгүй. Энэ нь эдгээр орныг орчин үеийн шинжлэх ухааны ололттой хөл нийлүүлэн уралдах чухал хөшүүрэг болж байна. Орчин үеийн хөгжлийн үйл явцаас хоцрохгүй, тэр тусмаа тэргүүний эгнээнд явах нь нийгмийн бүх гишүүдэд тэгш адилаар авьяас чадлаа гаргах чөлөөт бололцоог бүрэлдүүлэхэд оршиж байна. Социализм, капитализмын бүтээн байгуулалтын чөлөөт уралдаан нь дэлхий байтугай сансрын өргөн уудам зайг шаардана. Явцуу түгжигдмэл байдал, мөрдөн хардах арга, дэлхийгээс тусгаарласан хашлага хаалт бол дундад зууны хэрэм цайзын адил үеэ өнгөрөөжээ. Япончууд боловсролын дэвшилт тогтолцоог бүрэлдүүлэх, шинжлэх ухаан-техникийн мэдээлэл хөгжүүлэх, худалдаа-эдийн засгийн харилцааг өргөтгөх чиглэлээр чөлөөтэй, хол ойрыг харгалзаагүй байна. Энэ нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтаар дамжин үйлдвэрлэл, оюун ухааны шинэ шинэ эрэл хайгуулыг зогсолтгүй гүнзгийрүүлэх зайлшгүй шаардлагад хүргэжээ. Япон болон дорнод ахины бусад капиталист чиглэлийн улс орны хөгжлийн үйл явцад дотоодын олон талын бэрхшээл, доголдол байгаа нь мэдээж билээ.

Ирэх зууны босгыг алхахад ердөө аравхан жил үлдлээ. Ирэх зууны дэлхийн хөгжлийн дэвжээн дээр ямар байр суурьт орохоо энэ зууныг бараг хоцрогдол дунд өнгөрөөсөн дорнодахины олонхи улс түмэн байтугай, нэгэнт олсон байр сууриа хадгалж чадах, чаддаг ч гэсэн аль хирд орохоо өрнөдийн гүрнүүд ч сэтгэл догдлон хүлээж байна. Дэлхийн улс түмний хөгжлийн энэхүү нүргээнтэй үйл явц дунд ази, дорнодахины улс түмэн бүр чадлаа сорино.

Энэ зууны сүүлийн арван жилд Өмнөд Солонгос, Сингапур, Сянган, Тайван шинжлэх ухаан-техникийн нэлээд үзүүлэлтээр Японыг гүйцэж магадгүй байна. Өнөөгийн байдлаар ч Өмнөд Солонгос нь ган хайлуулах технологиор Японыг нэгэнт давжээ. Өмнөд Солонгос нь Японоос бага зардал гарган илүү чанартай автомашин үйлдвэрлэдэг боллоо. Японтой харьцуулахад бага зардал гарган илүү технологид түшиглэн илүү хийцний усан онгоц үйлдвэрлэж байна. Ийнхүү наяд онд АНУ-ыг Япон шахаж байсан шиг ерээд онд Японыг Өмнөд Солонгос зэрэг нэлээд орнууд шахах төлөв харагдаж эхэллээ. Үүнтэй холбогдуулан хүн хүч цөөтэй бага орон шинжлэх ухаан-техникийн өндөр хөгжилд бие даан хүрч чадахгүй мэтээр мэхлэхийг оролддог их гүрний дээрэнгүй үзэлтнүүдийн суртал нэвтрүүлэг бодит байдал, түүхэн үнэний шалгуур даахгүйг дорно дахины улс түмний туршлага, үүний дотор Сингапурын туршлага нотлон харуулж байна.

Төмөрлөг хайлах боловсруулах авсаархан үйлдвэр, электрон, хими, суурь багажийн аж үйлдвэрийг авсаархан загвараар байгуулж, ямар ч салбарын техник, технологийг бүтээж болдогийг Люксембург зэрэг өндөр хөгжилтэй, цөөн хүн амтай, нутаг дэвсгэр багатай улс, орны туршлага урьд ч харуулсаар ирсэн, өнөө ч харуулж байна. Цаашдаа ч цөөн хүн амтай олон орон төрийн болон эдийн засгийн тусгаар тогтнол, үндэсний соёл иргэншлээ хадгалсаар хөгжингүй түвшинд бие даан хүрнэ гэдэгт ямар нэгэн эргэлзээ үгүй боллоо. Түүхэн үнэнийг амьдрал нотолж өглөө. Хөгжиж байгаа улс түмний олонхи нь цөөн хүн амтай, нутаг багатай, эрдэс баялагийн нөөц тэр бүр элбэггүйтэй холбогдон бие даан хөгжих асуудлаар нэгэн үе маргал-

даж байсан бол тэр нэгэнт шийдвэрлэгдсэн байна. Алив улс орны бие даан хөгжих, хөгжингүй түвшинд хүрэх үндсэн гол баталгаа нь эцсийн эцэст өөрсдийн нь шинжлэх ухааны бүтээлч сэтгэлгээний нөөц байна. Үүний урьдчилсан нөхцөл нь үндэсний соёл иргэншлийн шимт хөрсөнд тулгуурлан олон улсын оюун сэтгэлгээний өргөн мэдээллээр хангагдсан үндэсний бие даасан сэтгэлгээ байна. Сингапурчууд аль нэгэн хэвшмэл номлол биш харин эрүүл санаа, практик үр ашгийг урьдал болгосон уян хатан идэвхтэй үйл ажиллагаа явуулсанд тус орны амжилтын гол сурвалж оршиж байна. Тэд өрнөдөөс шинжлэх ухаан-техникийн шинэ мэдлэгээс хоцрохгүйгээр барахгүй, түүнээс илүүтэй хөгжих, нийгмийн бусад асуудалд өнгөрсөн уламжлалдаа түшиглэнэ гэсэн чиглэлийг нийтээр баримталж байна. Тэргүүний туршлагыг хэрэглэх, харилцааг өргөтгөхөд нийгмийн байгууллын ялгааг хар галзахгүй гагцхүү бодит үр дүнг харгалзах зарчим тус орны нөхцөлд нааштай үүрэг гүйцэтгэж байна.

Өрнөдийн технологийг ашиглахаас өөр урагшлах арга анхлаад байгаагүй нь зүй бус боловч өнөө тэдгээр хөгжингүй орныг гүйцэхийн тулд молекул биологийн хүрээлэн ажиллуулж байна. Биологиос гадна сансрын холбоо зэрэг хэд хэдэн салбарын судалгаанд Сингапурын засгийн газар 1,5 сая доллар ойрын таван жилд зарцуулах гэж байна. Байгалийн нөөцгүй шахам энэ орны баян элбэгийг хангах цаглашгүй нөөц нь шинжлэх ухааны бүтээлч сэтгэлгээ, уйгагүй хөдөлмөр, үр ашигтай зохион байгуулалт юм. Иймээс ч тус хот-улсын бүх шатны сургуульд компьютер нэвтэрчээ. Компьютерын технологи зохион бүтээхэд үндэсний орлогыг зарцуулах хувиар АНУ-аас дээгүүрт орж байна. Энэ оронд бичиг цаасны ажлыг компьютерээр орлуулж байна. Тус орны оюутан өөрийн сургуулийн танхим төдийгүй дэлхийн нэртэй номын сангийн бүтээлийг гэрийнхээ компьютерээр удахгүй хардаг болох гэж байна. Ийм нөхцөлд оюутны мэдлэгт хичнээн том ахиц гарах бэ гэдгийг тайлбарлах нь илүү юм. Хөгжлийн үйл явцыг түргэтгэх аль ирээдүйтэй салбарын шинжлэх ухаан-үйлдвэрлэлд хүчээ төвлөрүүлэх уян хатан гавшгай, хөнгөн шаламгай ажиллагаа энэ бяцхан орныг дэлхийн тэргүүний дэвжээнд хүргэж байна.

Малайзи компьютер хэрэглэх талаар дээгүүрт оржээ. 12,2 сая хүнтэй 333 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай энэ орон 200 сая хүртэл долларыг компьютер хэрэглэхэд зарцуулж, тус орны энэхүү салбарын хөдөлмөрийн бүтээмж дэлхийд хосгүй түвшинд хүрчээ. Хэдийгээр америкийн техник үлэмж ашиглаж байвч цаашид түүнийг сайжруулан, Японоос давж гарч байна. Хагас дамжуулагч үйлдвэрлэх талаар АНУ, Японы дараахь байрыг баттай эзэлсэндээ малайзчууд тайвширсангүй, харин уул хагас дамжуулагчаар электрон багаж төхөөрөмж үйлдвэрлэх, хүнд үйлдвэрийн өгөөжтэй салбарыг хөгжүүлэх зэрэг хэтийн төлөвтэй салбарын технологи тийш засгийн газар нь анхаарлаа тавьжээ. Зуун мянга хүртэл автомашин гадаадад гаргахыг эрмэлзэж байна. Хэдийгээр японы пүүстэй хувь нийлүүлэн далан хувийг малайзын хөрөнгө эзэлж байгаа боловч бүх сэлбэгийг ойрын хугацаанд өөрөө үйлдвэрлэх зорилт тавьж байв. Малайзын микроэлектроны судлалын хүрээлэн тус орны хөгжилд чухал эрх үүрэгтэй ажиллах болжээ. 1987 онд малайзи 1,5 сая өнгөт телевизор үйлдвэрлэсэн бол 1990 онд 6 саяыг үйлдвэрлэнэ. Малайз хэдийгээр япон зэрэг орны тэргүүний техникт түшиглэх, хувь нийлүүлсэн үйлд-

вэр байгуулах зэргээр зүүн өмнөд азийн бусад орны адил хөгжлийн гараагаа эхэлсэн нь мэдээж боловч хөгжлийн үйл явцыг ухамсартай залж шинжлэх ухаан үйлдвэрлэлийг нийлүүлэх, тэргүүний технологи эзэмшихээс зохион бүтээхэд шилжих үйл явцыг чадамгай хосолж байна. Энэ талаар Сингапурын хөгжилтэй ана мана байгаа орон гэж малайзыг хэлж болно.

Тайланд өнөө гадаадад бүтээгдэхүүнээ гаргахад үйлдвэрийн хүч чадал нь чиглэсэн орон болон хувирчээ. АНУ, өрнөд еврол, австралийн зах зээлд тайландын хүнсний лаазалсан бүтээгдэхүүн 10 сая тонн хүртэл жил тутам гарч байна. Гутал хувцас их хэмжээгээр бас гарч байна. Энэ нөхцөлд түшиглэн үйлдвэрлэлийн багаж хэрэгслийнхээ хөгжилд нэлээд анхаарал тавьж байна. Тайланд ойрын жилд канадад 150 мянган автомашин гаргах, электрон техникийн үндэсний чадавхийг дээшлүүлэхэд багагүй хүч тавьж байна.

Индонези хүн ам олонтой, олон мянган арлын орон болохоор хөгжлийн бэрхшээл харин ч бага улс орноос илүүтэй юм. Индонези хэдэн удаа туршилтын хиймэл дагуул хөөргөж дөрвөн загварын нисдэг тэрэг, хоёр загварын нисэх онгоц үйлдвэрлэж байна. Тэдний энэхүү бүтээгдэхүүн, сэлбэг хэрэглэлийг АНУ, Саудын араб, Турк, Өмнөд Солонгос зэрэг орон авч эхэллээ. Сансрын болон агаарын аж үйлдвэрийн үндэсний биеэ даасан салбараа тэд төмөрлөг хайлах, боловсруулах, суурь багажийн үйлдвэрийн хөгжлийн өгөөж гэж үзэж байна. Тус орон биологи, хими, электрон бусад олон салбарыг зэрэг хөгжүүлэх хүн хүчний арвин нөөцтэйд хэн ч эргэлзэхгүй байна. Энэ мэтээр Азийн олон орон үндэсний аж үйлдвэрээ, эх орны шинжлэх ухаанд тулгуурлан хөгжүүлэх чиг шугам баримтлан, жижиг орон нь голчлон микроэлектроны систем хөгжүүлэн өөрсдийн микрокомпьютер үйлдвэрлэлийн зэрэг авсаархан бөгөөд өгөөжтэй салбарыг голчлон мөн микробиологи, биотехнологи бусад танин мэдэхүйн чиглэлд эрэл хайгуул хийсээр байхад Индонез, Пакистан, Энэтхэг мэт том орнууд нь хөгжлийн олон төрлийн салбарт хүч, хөрөнгө гарган орчин үеийн түвшинд хүрэхийн тул тус тусын загвараар явж байна. Эрдэмтэд инженер, зохион бүтээгчдийн бүтээлч санаачилга, судалгаанд улам таатай нөхцөл бүрэлдүүлж, тэр болон намуудын дотор дур зоригоор авирлах, түшмэдийн хүнд суртал, хээл хахууль нэвтрэх аюулыг сэрэмжлэх замаар бүтээлч олон түмэн, бүтээлч сэхээтний чөлөөт үйл ажиллагааг өрнүүлэх талаар орон тус бүр анхаарал тавьж байгаа нь хөгжлийн маш чухал урьдчилсан нөхцөл болж байна. Нөгөө талаар хөгжингүй орны капитал, техник мэргэжилтний хүчийг ашиглан, зээллэгийн хөрөнгийг зөв зарцуулан эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хөл дээрээ зогсох стратеги, тактикийг бодит тодорхой нөхцөлтэй чадамгай уялдуулснаар хөгжил нь илүү ахицтай, үндэсний шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн байр суурь бэхжиж байгаа ажээ. Эдгээр оронд нийгмийн маш олон асуудал байгаа нь мэдээж. Энэ бэрхшээлийг шийдвэрлэх замаа эдгээр улс түмэн олно гэдэгт эргэлзэхгүй байна.

Хөгжингүй орон байгалийн бохирдлыг багасгах, ажиллах хямд хүчийг ашиглах, үйлдвэрлэлээ борлуулалтын зах зээлд нь ойртуулах, илүүдэл мөнгийг бусад оронд зээлдүүлэн гүйлгээнд гаргах мэтийн сонирхлоо харгалзан хоршдог явдлыг хөгжил багатай орон аль болохоор ашиглаж өөрийн үндэсний эдийн засаг, шинжлэх ухаан, техни-

кийн бие даасан байдлын урьдчилсан нөхцөл болгож байна. Энэ бүхнийг хэрэгжүүлэх хугацааг урьдын адил олон арван жилээр сунжруулахгүй аль болох хурдан түргэнээр Хэгжлийн зангилаа асуудлыг шийдвэрлэх шатанд орох нь чухал ажээ.

Үүнд, жишээ нь Австрали, Шинэ Зеландийн шинжлэх ухаан-техникийн чадавхи, аж үйлдвэрийн шийдвэрлэх салбарын бүтэц цаашид хэлбэрэлтгүй шинэчлэгдэн ихээхэн хурдан хөгжих бололцоог нээж өгч байна.

Дээр дурьдсанаас үзэхэд Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжингүй орнуудын өмнө орчин үед биеэ даан хөгжих сайхан бололцоо нээгдэж байна.

1. Федерико Майор Сарагоса. На пути к новой этике «Курьер» июнь 1988 г.
2. «Диалог о едином мире», «Правда» 4 ноября 1988 г.
3. Сигэру Кимура. «Техника за гранью фантастики». («Курьер» январь 1988, стр. 33),

5 «За № 45»